



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар АБЭГ

Хөхбүрд

«Өвөл хаврын улиралд хурдан морины
уралдаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглосугай.

2. Дээрх хугацаанд хурдан морины уралдаан үсэргээн зохион байгуулахгүй байхыг нийт уяачид болон уяачдын холбоонд анхааруулсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Багийн Засаг дарга нар болон Хэсгийн төлөөлөгч (С.Дашбалбар), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Ө.Ариунзаяа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ж. ХАТАНБААТАР



642301001